

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2017 оны дугаар сарын –ны
өдрийн дугаар тушаалын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ХЭТИЙН /БИЗНЕС/ ТӨЛӨВЛӨГӨӨ

(2017-2020 он)

АГУУЛГА

I. ӨМНӨХ ҮГ

II. ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН МЭДЭГДЭЛ

III. НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
СТРАТЕГИ

IV. ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС НИЙЛҮҮЛЭХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

✓ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

V. ТӨСӨВЛӨСӨН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

VI. ӨМЧЛӨЛИЙН БУСАД ЗОРИЛТУУД

VII. УЛСЫН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨРИЙН ТӨСӨВЛӨСӨН
ТАЙЛАН

**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХЭТИЙН /БИЗНЕС/ ТӨЛӨВЛӨГӨӨ**

I. ӨМНӨХ ҮГ

Аливаа байгууллагын зах зээлийн нөхцөлд оршин тогтнох, хөгжих үндэс нь үндэслэлтэй боловсруулагдсан урт, дунд, богино хугацааны төлөвлөгөө бөгөөд тэрхүү төлөвлөгөөгөө амжилттай хэрэгжүүлэх арга замыг зөв бүрдүүлэх явдал юм. Иймд Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловруулж ажиллахаар төлөвлөж байгаа нь үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах боломжийг бүрдүүлэхэд дөхөм болно гэж бодож байна.

Засаг даргын Тамгын газрын стратеги төлөвлөгөөг “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”, “Засгийн газрын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Хан-Уул дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан боловсрууллаа.

Түүнчлэн “Монгол Улсын үндсэн хууль”, “Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”, “Монгол Улсын төсвийн тухай хууль”, “Монгол Улсын Төрийн албаны тухай хууль”, “Санхүү, эдийн засгийн сайдын 2003 оны 3 дугаар сарын 31-ний 93 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын үйл ажиллагааны хэтийн (бизнес) төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар”, “Төсвийн байгууллагын үйл ажиллагааны хэтийн (бизнес) төлөвлөгөө боловсруулах заавар” зэрэг эрх зүйн актуудыг тус төлөвлөгөөг боловсруулах явцад мөрдлөг болгон ажилласан болно.

II. ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН МЭДЭГДЭЛ

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2017-2020 онд хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулан Тамгын газраас төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд дүүргийн Засаг даргад өргөн мэдүүлж байна.

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар нь алсын хараа, эрхэм зорилго, баримтлах зарчим, стратегийн болон үйл ажиллагааны зорилтуудаа нарийвчлан тодорхойлсон бодлого, дор дурьдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн Хууль
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
- Монгол Улсын Төрийн албаны тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,
- Монгол Улсын төсвийн тухай хууль
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
- Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого
- Нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
- Бусад хууль тогтоомж зэрэг болно.

Төлөвлөгөөнд тусгагдсан эрхэм зорилго, стратегийн болон үйл ажиллагааны зорилтууд, Засгийн газрын болон дүүргийн Засаг даргын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг хангах, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогын холбогдох зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн.

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газраас хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээг тогтвортой мөрдөж, тухайн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээг шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх үр дүн, өртөг, түүнд шаардагдах төсвийн зардлын төлөвлөгөөг Засаг даргатай урьдчилан тохиролцооноор жил бүр тодотгон боловсруулж, батлуулан ажиллана.

Төлөвлөгөөний биелэлтийг жил бүр Засаг даргад тайлагнах, хүрсэн түвшинг баталгаажуулах, тогтвортой ахиулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж удаашралтай байгаа үйл ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар ажилтан, албан хаагчдыг үүрэг даалгавар, санал зөвлөмжөөр хангаж ажиллахаас гадна Тамгын газрын үйл ажиллагаа түүний үр дүнгийн талаар иргэдэд нээлттэй тайланган ажиллах болно.

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД

ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР Б.ЭНХБОЛД

201..... оны ... дугаар сарын ...-ны өдөр

3.1. Байгууллагын алсын хараа

Хүнээ эрхэмлэн дээдэлсэн, хүн амын хэрэгцээ шаардлага, дүүргийн онцлогт зохицсон, дэлхийн зах зээлд өрсөлдөх боломжтой, өндөр технологид суурилсан үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх замаар эрүүл аюулгүй орчинтой тэргүүлэгч дүүрэг болохыг эрмэлзэнэ.

3.2. Эрхэм зорилго, Эрхэмлэх үндсэн зарчим

Төр иргэн, хувийн хэвшлийн түншлэл, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа, бүтээлч оролцоонд тулгуурлан, төрийн албан хаагчдыг чадварлаг тогтвортой, хариуцлагатай баг бүхий төрийн үйлчилгээний загвар болоход оршино.

Бид үйл ажиллагаандаа дараах үндсэн зарчмыг эрхэмлэнэ. Үүнд:

- **Хууль дээдлэх:** ЗДТГ-ын ажилтан албан хаагчид хариуцсан ажилдаа бүтээлчээр хандаж, Төрийн албаны тухай хуулиар төрийн албанд “Ил тод байх” зарчмыг баримтлахыг мөрдлөг болгон сайн засаглалыг нийгмийнхээ хэрэгцээ шаардлагатай уялдуулан, асуудлаа хамт олноороо шийдвэрлэх үйл явц болно.
- **Мэргэшсэн байх:** Хариуцсан ажил үүргээ гүйцэтгэх хангалттай мэдлэг, чадварыг эзэмшин, түүнийгээ цаг үеийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, төрийн бодлогын залгамж чанарыг хангаж, мэргэшсэн үйлчилгээ дэмжлэгийг Засаг дарга, Тамгын газарт үзүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулна.
- **Багаар ажиллах:** Нэгдсэн зохион байгуулалттай, хөрвөх чадвартай мэргэшсэн, чадварлаг хамт олонд түшиглэсэн багийг бүрдүүлж ажиллана.
- **Хариуцлагатай байх:** Нийгмийн өмнө хүлээсэн төрийн албаны манлайлал, үүрэг хариуцлагаа ухамсарлаж, ажилдаа чин сэтгэлээсээ бүтээлч, санаачлагатай хуулийг дээдлэн ажиллана.
- **Санаачилгатай байх:** Дүүргийн Засаг даргын Тамгын газар нь өөрийн алсын хараагаар чиг баримжаа авч, үргэлж санаачлагатай өөр дээрээ туршин үр дүнтэй нь нотлогдсон шинэ дэвшилтэд туршлагаар бусдыг үлгэрлэн дагуулж, түүнийг нийтийн хүртээл болгоно.
- **Шуурхай, бүтээмжтэй байх:** Дүүргийн Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, иргэд олон нийтээс ирсэн эрэлт хүсэлт, дэвшүүлсэн асуудлыг хурдан шуурхай шийдвэрлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх;
- **Ил тод нээлттэй байх:** Мэдээллийн чөлөөт урсгал дээр үндэслэн, үйл ажиллагаа, тогтолцоо, үйлчилгээний мэдээлэл нь иргэдэд нээлттэй, ойлгомжтой байх, хяналт тавихад хангалттай мэдээллээр хангахуйц байна.

3.3. Нөхцөл байдлын шинжилгээ

Бидний тодорхойлсон эрхэм зорилго нь манай дүүргийн үйл ажиллагааны онцлог, өнөөгийн орчин нөхцөл байдлын шинжилгээнээс үндэслэлтэй болно. Тамгын газрын бүх удирдах бүрэлдэхүүн, ажилтан, албан хаагчдыг оролцуулан өнөөдөр бидэнд тулгарч буй асуудал, нөхцөл байдлаа гадаад болон дотоод орчин талаасаа тодорхойллоо.

ХҮСНЭГТ 1. ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗДТГ-ЫН СВОН ШИНЖИЛГЭЭ

Нэг. Дотоод хүчин зүйл	
Давуу тал	Сул тал
1. ЗДТГ болон хороодод Төрийн үйлчилгээг “Нэг цонх”-ны зарчмаар хүргэж төрийн байгууллага, иргэний харилцан итгэлцэл, хамтын ажиллагаа бэхжих боломжтой боллоо.	1. ЗДТГ-ын болон дэргэдэх хэлтсүүд холбогдох хэрэгжүүлэгч агентлагуудын хоорондын ажлын уялдаа холбоо сул.
2. Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дүүргийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн зорилт нь холбогдох дээд газрын хөтөлбөр, зорилттой уялдан боловсруулагдсан тул бүрэн хэрэгжих боломжтой.	2. ЗДТГ-ын хэлтсүүдийн мэдээлэл солилцоо, ажил үүргийн уялдаа холбоо сул, ажил үүргийн давхардал байгаагаас зарим ажлыг нэг нэгэн рүүгээ түлхсэнээс эзгүйрэх хандлагатай.
3. Нутгийн захиргааны байгууллагын бодлого шийдвэр гаргах үйл явцад олон нийтийн оролцоо нэмэгдэж байгаа нь Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлж байна.	3. Хэлтсүүдийн болон ажилтан, албан хаагчдын ажлын ачаалал харилцан адилгүй.
4. ЗДТГ-ын бүтцэд багтах батлагдсан орон тоонд ажилтан, ажиллагсдыг томилох, чөлөөлөх асуудлыг бие даан шийдвэрлэх боломжтой.	4. Тамгын газрын албан хаагчдын цалин нь айл өрхийн хэрэгцээг хангадаггүй, ажилтнуудын 90-ээс дээш хувь нь цалингийн зээлд хамрагдсан байдаг.
5. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралтай харилцан буюу хамтран ажиллах ажиллагаа төлөвшсөн.	5. Төрөөс хэрэгжүүлж буй нийгмийн чиглэлийн асуудлуудад хамрагдах боломж дутмаг
Хоёр. Гадаад хүчин зүйл	
Боломж	Бэрхшээл
1. Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэх эрх зүйн үндэс тавигдаж, ЗДТГ-ын ажлын ачаалал багасах боломж гарч ирж байна.	1. Дүүрэгт гэр хороолол өргөжин тэлснээр хөрс болон агаарын бохирдол ихэссэн
2. Төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчид намын гишүүнчлэлгүй болсноор, төрийн үйл ажиллагаанд иргэд бүхий л хэлбэрээр оролцдог байх бололцоог эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хийх боломж бүрдсэн.	2. Бусад төрийн байгууллагын нэгэн адил аливаа шийдвэр гаргалтанд намын бодлого чухал нөлөөтэй байгаагаас иргэдийг намаар талцах, улс төржихөд хүргэж, зарим чухал шийдвэрүүд хэрэгжихгүй байх, эсвэл онцын шаардлагагүй шийдвэр гарах, мэдлэг, чадвар, дадлага туршлага сул хүнийг чухал албан тушаалд томилох
3. Төрийн бүх шатны албан хаагчдын үүргийг тодорхой болгож, үүргийн биелэлтийг үндэслэн хариуцлага тооцдог болох механизм нэвтэрсэн.	3. Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлж буй нөлөө, үр дагавар
4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, төсвийн эрх мэдэл нэмэгдэж байгаа нь орон нутагтаа хөгжлийн бодлогоо бодитой	4. Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах ашиглалтын шаардлага хангахаа больсон барилга, байгууламжууд бий болж байна.

төлөвлөж хэрэгжүүлэх боломжтой болж байна.	
5. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг томоохон аж ахуйн нэгж байгууллагууд байрладаг тул бусад дүүргүүдтэй харьцуулахад ажилгүйдэл ядуурлын түвшин харьцангуй бага	5. Байр, орон сууц ихээр баригдаж эхэлснээс үүдэн дүүргийн суурин хүн амын төвлөрөл ихэсч, эдийн засагт нөлөөлөх хандлагатай.
6. Засаг даргын Тамгын газар нь өөрийн байртай.	6. Төр захиргааны байрууд нэг дор ойр байрладаг тул аавтомашинны зогсоолын хүрэлцээ муу, түгжрэл ихээр үүсдэг.

3.4. Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын стратегийн зорилт

Бид өөрийн байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлж буй гадаад дотоод орчин, нөхцөл байдлын шинжилгээндээ тулгуурлан дэвшүүлсэн эрхэм зорилгодоо хүрэх дараах стратеги зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

Стратегийн зорилт 1.

Төрийн үйлчилгээг нээлттэй, хөнгөн шуурхай, ил тод болгох замаар төр, иргэн, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх

Стратегийн зорилт 2.

Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг мэргэшүүлэх, урамшуулах, албан тушаал ахиулах зарчмыг баримтлан мэргэшсэн, чадварлаг, туршлагатай хүний нөөцийн баг бүрдүүлж, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцлийг бүрдүүлж, нийгмийн баталгааг хангуулах

Стратегийн зорилт 3.

Иргэдэд хүрэх төрийн үйлчилгээнд цахим технологийг нэвтрүүлж, мэдээллийн технологиор тэргүүлэх дүүрэг болох

Стратегийн зорилт 4.

Гадаад орны ижил төрлийн байгууллагуудтай тогтоосон хамтын ажиллагааг дүүргийн дахин төлөвлөлт, байгаль орчин, хөдөө аж ахуй, боловсролын хөгжил рүү чиглүүлэх

Стратегийн зорилт 5.

Төр захиргааны үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлж, дүүрэг эдийн засгийн хувьд бие дааж хөгжих

Стратегийн зорилт 6.

Дүүргийн хөгжлийг тодорхойлохуйц тохижилт, бүтээн байгуулалт, ногоон байгууламж, гэрэлтүүлэг, агаарын бохирдлыг бууруулах, хог хаягдлын менежментийг сайжруулж, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх

Стратегийн зорилт 7.

Байгаль орчинд ээлтэй “ЭКО-ДҮҮРЭГ” болох

Стратегийн зорилт 8.

Хөдөө аж ахуй, аялал жуулчлал, үйлдвэрлэл, худалдаа, нийтийн хоол, ахуй үйлчилгээний салбарт бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагаадыг хууль тогтоомжийн хүрээнд дэмжиж, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, дүүргийн эдийн засгийн бааз суурийг бэхжүүлэхэд чиглүүлэх.

3.5. Үйл ажиллагааны хамрах хүрээ

А. Хан-Уул дүүргийн газар нутаг. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг нь БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1965 оны 4 дүгээр сарын 14-

ний өдрийн 79 дүгээр зарлигаар “Ажилчны район” нэртэйгээр байгуулагдсан нийслэлийн ууган дөрвөн дүүргийн нэг юм. Тус дүүрэг нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын баруун урд хэсэгт дархан цаазат Богд хан Уулын ар хормой, Хатан Туулын хөвөөнд оршдог бөгөөд Монгол Улсын үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд “Нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлага”-тай хослуулан төрийн эрх, үүргийг хэрэгжүүлж байгаа нутаг дэвсгэр, засаг захиргаа, эдийн засгийн бие даасан үйл ажиллагаатай цогцолбор бөгөөд 48500 га нутаг дэвсгэртэй, үүнээс 21.1 хувь буюу 10226 га нь ой мод, гол горхи, рашаан ус бүхий дархлагдсан ногоон бүс, 67,6 хувь буюу 32763 га нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 11,3 хувь буюу 5499 га нь хот суурин, зам харилцааны сүлжээ, нийтийн эзэмшлийн газарт хамаардаг.

Тус дүүргийн нутаг дэвсгэрт орших Богд Хан-Уул нь эрт үеэс буюу 1775 оноос эхлэн төрийн тахилгатай болсон дархан цаазат хайрхан бөгөөд ноён оргил Түшээ гүн нь далайн төвшнөөс дээш 2268 метр, Цэцээ гүн нь 2256 метр өндөрт өргөгдсөн байдаг.

Богд Хан-Уулын эзлэх талбай нь 40.8 мянган га бөгөөд 33 амнаас нь булаг, гол горхи ундрэн хөвч ой нь 9 төрлийн мод, 78 төрлийн ан араатан, 420 гаруй зүйлийн цэцэгт болог бутлаг ургамал 45 зүйлийн хөхтөн, 5 зүйлийн хоёр нутагтан 116 зүйлийн жигүүртэн бүхий байгалийн үзэсгэлэнт газар билээ.

Богд Хан-Уулыг тойрсон эртний домогт уул овоо толгод олон бий. Зэндмэнэ толгой, Зайсан толгой, Ар Зайсан, Өвөр Зайсан, Бөхийн овоо, Умаа хум толгой, Сонсголон толгой, Манзуширийн хийд, Айдсын даваа, Буянт-Ухаа, Яармагийн дэнж зэрэг газрууд бол тодорхой цаг үеийн үйл явдлын бодит гэрч болсон түүхэн дурсгалт газрууд юм.

Б. Нийгэм эдийн засаг захиргааны хүрээ. Монгол Улсын аж үйлдвэрийн өлгий нутаг бөгөөд хөнгөн аж үйлдвэрийн салбар илүү хөгжсөн, мал аж ахуй, газар тариалан, дэд бүтцийн хувьд давуу талтай учраас эдийн засгийн чөлөөт бүсийн тааламжтай нөхцөл бүрдсэн онцлогтой дүүрэг билээ.

Тус дүүрэг нь **47202** мянган өрхийн, **169726** мянган хүн амтай, газар нутгийн хэмжээ нь 484.7 мянган га нутаг дэвсгэртэй, аж үйлдвэр, мал аж ахуй, газар тариалан, дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн эдийн засаг, нийгмийн цогцолбор бөгөөд засаг захиргааны бүтцийн хувьд төрийн захиргааны чиг үүрэг бүхий дүүргийн Засаг даргын Тамгын Газартай, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албатай, засаг захиргааны 16 хороотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Дүүргийн аж үйлдвэрийн газрууд 2017 онд 830.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 850.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн оноос үйлдвэрлэлт 17.4 хувиар, борлуулалт 34.8 хувиар тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн нийт борлуулалтын 642.3 тэрбум төгрөгийг дотоодод 207,8 тэрбум төгрөгийг борлуулсан байна.

Нийт борлуулсан бүтээгдэхүүний 24.4 хувийг экспортод гаргасан бөгөөд нийт экспортын 97.0 хувийг ноос, ноолуур, нэхмэлийн үйлдвэрлэлт, 0.4 хувийг ундаа үйлдвэрлэлт, 0.7 хувийг мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, 0.7 хувийг ашигт малтмалын олборлолт тус тус эзэлж байна.

2017 оны жилийн эцсийн мал тооллогод 840 малтай өрх, үүнээс 56 малчин өрх хамрагдан нийт 35780 толгой мал тоологдсон нь урьд оныхоос 4366 толгой мал буюу 13,8 хувиар өсчээ.

Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгж, байгууллага 2017 онд 34.9 га талбайд төмс, 155.1 га талбайд хүнсний ногоо тус тус тариалжээ. Нийт 17.4 га хүлэмжийн талбайд ногоо тарьсны 55.2 хувийг өргөст хэмх, 29.3 хувийг улаан лооль, 9.2 хувийг бусад хүнсний ногооны тариалалт эзэлж байна. 2016 онтой харьцуулахад төмс тариалалт 1 га талбайгаар, хүнсний ногоо тариалалт 15.8 га талбайгаар өсчээ.

2017 оны мал тооллогоор нийт 33208 толгой мал тоологдсон нь 2016 оноос 5277 (13.7%) толгой малаар буурсан байна. Нийслэлийн хэмжээнд 2017 онд 411781 толгой мал тоологдсон бөгөөд дүүргийн мал 8.1 хувийг эзэлж, өмнөх оноос 1.0 пунктээр буурсан байна. Дүүргийн нийт малын тоо, оноор Малын таван төрлөөр өмнөх онтой харьцуулахад тэмээ 2 толгойгоор (3.0 дахин) өсч, адуу 502 толгойгоор (8.0%), үхэр 1385 толгойгоор (11.0%), хонь 1318 толгойгоор, (13.3%) толгойгоор, ямаа 2074 толгойгоор (21.3%) тус тус буурчээ. Иргэдийн хувийн мал 32980 толгой, аж ахуйн нэгж, байгууллагын мал 220 болж өмнөх оноос иргэдийн ШТС Шатахуун, төрлөөр Аи 95 Аи 80 Аи 92 Дизель түлш Газ Жаст Ойл 1 780 1 840 2 350 Петровис 2 295 1 795 1 840 2 385 Магнай трейд 2 340 1 880 2 380 Сод монгол 2 300 1 890 2 380 Шунхлай 2 320 1 850 1 885 2 385 Юнигаз 1 300 Дундаж үнэ 2 314 1 808 1 867 2 376 1 300 36990 42686 37520 38860 38485 33208 2013 2014 2015 2016 2017 2018 42 мал 4860 (12.8%) толгойгоор буурч, аж ахуйн нэгж, байгууллагын мал 425 (65.9%) толгойгоор буурчээ.

В.Гадаад харилцаа хамтын ажиллагаа.

Тус дүүргийн гадаад харилцаа эрчимтэй хөгжиж, БНСУ-ын Сөүл хотын Гуанжин дүүрэг, Гёнсан аймгийн Хаман сум, Бусан хотын Хэүндэ дүүрэг, Жинжү хот, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хот, БНБУ-ын Софи хотын Изгрев дүүрэг, Япон Улсын Мусашимураяама хот зэрэг газруудад хамтын ажиллагаа тогтоон төрийн захиргаа, боловсрол, эрүүл мэнд, соёл, спорт, эдийн засаг, хөрөнгө оруулалт, хөдөө аж ахуй, бизнесийн чиглэлээр үр ашигтай хамтран ажиллаж байна. Үүнд:

- БНСУ-ын Гёнсан аймгийн Хаман сумын мэргэжилтэн, албан хаагчид дүүргийн тариаланч иргэдэд жил бүр хүлэмжийн аж ахуйн сургалтыг амжилттай зохион байгуулж байна.
- БНСУ-ын Бусан хотын Хэүндэ дүүргийн харъяа “Сайн дурын үйлчилээ үзүүлэх төв”-ийн ажилтан, албан хаагчид жил бүр дүүргийн цэцэрлэгийн гадна зам, талбайг засварлан шинэчилж цэцэрлэгийн хүүхдүүдэд сургалт зохион байгуулж байна.

Г.Боловсрол, соёл шинжлэх ухаан.

- Төрийн өмчийн 28, төрийн бус өмчийн 80 цэцэрлэгт нийт 14048 хүүхэд хамрагдсан бөгөөд төрийн өмчийн цэцэрлэгт 881, төрийн бус өмчийн цэцэрлэгт 756 ажилтан ажилласан байна. Төрийн өмчийн цэцэрлэгийн үндсэн багшаар 235, төрийн бус өмчийн цэцэрлэгийн багшаар 262 багш ажилласан.
- Төрийн өмчийн 19, төрийн бус өмчийн 13 ерөнхий боловсролын сургуульд нийт 25532 хүүхэд суралцсан бөгөөд төрийн өмчийн сургуульд 1458, төрийн бус өмчийн сургуульд 519 ажилтан ажилласан байна. Төрийн өмчийн сургуулийн үндсэн багшаар 985, төрийн бус өмчийн сургуулийн багшаар 292 багш ажилласан.

Д.Урлаг спорт.

Тус дүүргийн нутаг дэвсгэрт Монгол Улсын төв цэнгэлдэх хүрээлэн байрладаг ба үндэсний баяр наадмыг жил бүхэн энэхүү цэнгэлдэх хүрээлэнд хийдэг. Буянт-Ухаа дахь 6000 хүний суудалтай орчин үеийн спортын ордон бий. Тус дүүргийн дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгжийн 100 гаруй спортын танхим, чийрэгжүүлэлтийн талбай байдаг.

Тус дүүрэгт соёлын төв, нийтийн номын сан, их дээд, дунд сургууль, коллежийн номын сан 37, түүх соёлын дурсгалт газар 14 тус тус ажиллаж урлаг, соёлын үйлчилгээг үзүүлж байна.

Е.Эрүүл мэнд. Тус дүүрэгт Эрүүл мэндийн нэгдэл, нэгдсэн эмнэлэг, лаборатори, рашаан сувилал, эмийн сангууд, өрхийн эмнэлгүүд нийт 87 орчим ажиллаж хүн амд эрүүл мэндийн анхан шатнаас нарийн шинжилгээг чанартай шуурхай, хүртээмжтэй хүргэх ажлыг гүйцэтгэдэг.

Ё.Аялал, жуулчлал.

Дэлхийн эдийн засаг, мөнгөний эргэлтийг хөдөлгөгч нийгмийн хөдөлгүүр нь аялал жуулчлал болж байна. Нөгөөтэйгүүр аялал жуулчлал нь “утаагүй үйлдвэрлэл”, “үл үзэгдэгч экспорт” гэдэг сонгодог утгаараа дэлхий дахинд эрчимтэй хөгжиж байгаа юм.


Дүүргийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 48 гаруй аж ахуй нэгж байна. Үүнд жуулчны бааз 6, амралтын газар 8, зочид буудал 25, дэн буудал 9 байна. Эдгээрт 1000 гаруй хүн ажилладаг бөгөөд дүүргийн аялал жуулчлалын газрууд нь нэг ээлжинд 1800 орчим хүнд зэрэг үйлчлэх хүчин чадалтай юм.

Байгалийн үзэсгэлэнт дархан цаазат Богд хаан уулын амуудад байрлах жуулчны баазууд нь жилдээ 60-80 мянган жуулчин хүлээн авах хүчин чадалтай бөгөөд энд Нүхт, Чингисийн хүрээ, Монголика, Мөнхтэнгэр-2 богд, Их тэнгэр, Нормантур, Ривер хаус, зэрэг томоохон жуулчны баазууд ажиллаж байна.

Мөн гадаадын төдийгүй дотоодын жуулчдын сонирхлыг ихээхэн татдаг түүх соёлын үнэт дурсгал болох Богд хааны зуны ордон музей, Зайсан толгой дахь Монгол-Зөвлөлтийн дайчдын цогцолбор, Бурхан багшийн сэрэг хөшөө, Үндэсний далбаат цогцолбор, дархан цаазат Богд хаан уул, Чингис хааны сэрэг дүр бүхий Умаахан уул, Соёмбот толгой болон эмчилгээ сувилгааны өндөр үр өгөөжтэй Дондогдулам хатны рашаан зэрэг түүх дурсгалын болон байгалийн үзэсгэлэнт газрууд манай дүүрэгт байдаг.

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗДТГ-ЫН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Схем 1



3.6 Эн тэргүүнд худалдан авах бүтээгдэхүүн

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар нь стратегийн зорилтоо ханган биелүүлэхийн тулд ирэх 4 жилийн хугацаанд нийлүүлэхээр тодорхойлсон нийт 6 ангийн 17 ажил, үйлчилгээ, тэдгээрийг нийлүүлэхэд чиглэсэн 35 үйл ажиллагаа / ажил үйлчилгээ/-г эрхлэн зохион байгуулж, гүйцэтгэлийг ханган ажиллана.

Хан-Уул дүүргийн Тамгын газраас Засаг даргад нийлүүлэх бүтээгдэхүүн

Хүснэгт 3.1

Бүтээгдэхүүний анги		Тамгын газраас нийлүүлэх ажил, үйлчилгээ		Бүтээгдэхүүн нийлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа /ажил үйлчилгээ/	
№	Нэр	№	Нэр		
1	Төрийн захиргааны бодлого зохицуулалт, үйлчилгээ	1.1	Засаг даргад үзүүлэх захиргааны үйлчилгээ	1.1.1 Захирамжлалын баримт бичгийн биелэлт, үүрэг даалгаврыг хангуулж Засаг даргын өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах, мэдээллээр хангах үйл ажиллагаа	
				1.1.2 ЗДТГ-ын жилийн төлөвлөгөөний биелэлтийг хангуулах	
		1.2	Захиргаа, хууль эрх зүй, хүний нөөцийн удирдлага, зохицуулалт	1.2.1 Хууль, эрх зүйн бодлого зохицуулалт	
				1.2.2 Олон нийт, иргэдийн эрэлт хүсэлтийн бодлого зохицуулалт	
				1.2.3 Архив, албан хэрэг хөтлөлт	
				1.2.4 Хүний нөөцийн бодлого зохицуулалт	
		1.3	Үйл ажиллагааны хяналт, шинжилгээ үнэлгээ	1.3.1 Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтын хэрэгжилтийн хяналт	
				1.3.2 Тогтоол шийдвэр, хөтөлбөр, төслийн хэрэгжилтэнд тавих хяналт	
		1.4	Гадаад харилцаа, хэвлэл мэдээллийн бодлого зохицуулалт	1.4.1 Мэдээллийн технологи, сүлжээний ашиглалт, зохицуулалт	
				1.4.2 Гадаад харилцааны бодлого зохицуулалт	
		1.5	Байгууллагын хөгжил	1.5.1 Тамгын газрын санхүүгийн чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн ажил үйлчилгээ	
				1.5.2 Тамгын газрын материаллаг нөөцийг сайжруулахад чиглэсэн ажил үйлчилгээ	
		2	Эдийн засгийн бодлого	Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах	2.1.1 Нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр НЭЗЗ –ийн хэрэгжилтийг хангах, мэдээ тайлан гаргана.
					2.1.2 Орон нутагт шаардлагатай хөрөнгө оруулалтын ажлын саналыг нэгтгэн, Улс, нийслэлийн төсөвт тусгуулах, хэрэгжилтэд хяналт тавих
2.1.3 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын даалгавар, зураг төслийн ажлыг зохион					

3	Санхүү, эдийн засгийн бодлого, зохицуулалт		байгуулж, гүйцэтгэлд хяналт тавих		
		2.2	Үндэсний болон дэд хөтөлбөр, Орон нутгийн хөгжлийн асуудал	2.2.1 ЗГ болон Нийслэлийн ИТХ-аар батлагдсан хөтөлбөрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан мэдээ гаргах 2.2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажил үйлчилгээг удирдлага зохион байгуулалтаар ханган, хэрэгжилтэд хяналт тавих	
		2.3	Дахин төлөвлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулан, иргэдийг мэдээлэлээр хангах	3.3.1. Гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд зохион байгуулан мэдээ тайланг гаргах	
				3.3.2 Ашиглалтын шаардлага хангахгүй Нийтийн орон сууцны барилгын дахин төлөвлөлттэй холбоотой үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд зохион байгуулан мэдээ тайлан, мэдээ гаргах	
	3	Санхүү, эдийн засгийн бодлого, зохицуулалт	3.1	Төсөв, санхүүгийн төлөв байдал, хандлага, чиглэлийн боловсруулалт	3.1.1 Орон нутгийн төсвийн жилийн болон дунд хугацааны төслийг үндэслэлтэй боловсруулах, хянах, нэгтгэн тооцоолж Нийслэлийн СТСХ-т хүргүүлж нэгтгүүлэх, дүүргийн ИТХ-д өргөн барьж батлуулах,
					3.1.2 Төсвийн сар, улиралын хуваарийг хийх, төсвийн зориулалт, зарцуулалтанд хяналт тавих, төсвийн байгууллагаас нийлүүлэх бүтээгдэхүүнийг эцсийн үр дүнгээр нь санхүүжүүлэх
					3.1.3 Төсвийн байгууллагаас нийлүүлэх бүтээгдэхүүнийг эцсийн үр дүнгээр нь санхүүжүүлэн төсвийн бодит хэмнэлт үр ашгийг дээшлүүлэн удирдлагыг цаг үеийн үнэн зөв мэдээлээр хангах
			3.2	Төсөв, санхүүгийн бодлого, зохицуулалт, тайлагнал	3.2.1 Төрийн сангийн нэгж төсөвт байгууллагуудад Засгийн газрын шинэчилсэн бүртгэл болон улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг хэрэгжүүлэх ажлыг хангуулах.
	3.2.2 Төсөвт байгууллагуудын тайлан тэнцлийг хүлээн авч баталгаажуулан нэгтгэл хийх, орон нутгийн болон төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлан тэнцлийг гарган аудитын байгууллагаар баталгаажуулан, төсвийн зардлын гүйцэтгэлд судалгаа шинжилгээ хийх.				
	3.3		Төрийн сангийн үйлчилгээ	3.3.1 Төсөвт байгууллагад Төрийн сан банкны үйлчилгээг үзүүлэх, төсвийн сахилга батыг ханган биелүүлж, зөрчилгүй ажиллах	
3.3.2 Дүүргийн харьяа төсөвт байгууллагуудын төрийн санд болон арилжааны банкинд нээгдсэн дансны хяналтыг хэрэгжүүлэх					
3.3.3 Төсөвт байгууллагын төлбөр тооцоог программд эцэслэн гүйцэтгэж хэвших, программыг ажилдаа бүрэн нэвтрүүлэх					
3.4	Төсвийн орлогын		3.4.1 Татварын бааз суурийг нэмэгдүүлж, төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх		

			бүрдүүлэлт	
		3.5	Нягтлан бодох бүртгэлийн стандартыг хангуулах	3.5.1 Тайлан тэнцлийн нэгтгэлийг хуулийн хугацаанд зохих дээд байгууллагад хүргүүлэх 3.5.2 Ажлын тайлан болон хугацаат мэдээг хуулийн хугацаанд нь хүргүүлэх
		3.6	Хөрөнгө оруулалт, орон нутгийн өмчийн бүртгэл	3.6.1 Тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын ажлууд нь хуулийн дагуу хугацаандаа, чанартай гүйцэтгэх, хөрөнгийн бүртгэлийг хийж, мэдээллийн сан бүрдүүлэх
4	Дэд бүтэц, тохижилтын талаарх бодлого зохицуулалт, үйлчилгээ	4.1	Тохижилт, Гэрэлтүүлэг, СӨХ, хог хаягдал, байгаль орчин, ногоон байгууламж	4.1.1 Дүүргийн нийтийн эзэмшлийн болон орон сууцны дундах тохижилт, гэрэлтүүлэг, СӨХ-ийн үйл ажиллагаанд хяналт, зохицуулалт
				4.1.2. Байгаль орчны эрх зүйн зохицуулалт болон болон дүүргийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн болон орон сууцны дундах ногоон байгууламж болон цэцэрлэгжүүлэлтийн үйл ажиллагааны хяналт, зохицуулалт
				4.1.3. Дүүргийн болон хорооны нутаг дэвсгэрийн хог хаягдлын менежментийг сайжруулах, хог тээвэрлэлтийн үйл ажиллагаанд тавих хяналт, хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх эрх зүйн зохицуулалт
		4.2	Агаарын бохирдол	4.2.1. Агаарын бохирдлыг бууруулахад авах арга хэмжээ, түүнд тавих хяналт, зохицуулалт
		4.3	Зам барилга, холбоо, инженерийн байгууламж	4.3.1. Дүүргийн нутаг дэвсгэр дэхь авто замын арчлалт хамгаалалт, түүнд тавих хяналт зохицуулалт
				4.3.2. Дүүргийн нутаг дэвсгэр дэх байрилга байгууламжийн ашиглалт, бүртгэл хяналт, зохицуулалт
				4.3.3. Дүүргийн нутаг дэвсгэр дэх усан хангамж, цахилгаан хангамж, дулаан хангамж түүнд тавих хяналт, зохицуулалт
5	Нийгмийн бодлого зохицуулалт	5.1	Боловсрол, төрийн бус байгууллагын бодлого, зохицуулалт	5.1.1 Нийслэл, дүүргээс боловсрол, төрийн бус байгууллагын талаар баримтлах бодлого хууль тогтоомжийг дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, боловсролын чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагын ажлын уялдаа холбоог зохицуулах чиглэлээр бодлогын зөвлөгөө, мэдээллээр хангах
		5.2	Эрүүл мэнд, биеийн тамирын бодлого зохицуулалт	5.2.1 Эрүүл мэнд, биеийн тамирын чиглэлээр дүүргийн Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд төрөөс эрүүл мэнд, биеийн тамирын талаар баримтлах бодлого, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах бодлого зорилтыг хэрэгжүүлэх, биеийн тамирын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зөвлөгөө мэдээллээр хангах
		5.3	Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын	5.3.1 Дүүргийн Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд төрөөс хөдөлмөр, нийгмийн хамгааллын талаарх хууль тогтоомж, ядуурал, ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөр

			бодлого зохицуулалт	эрхлэлт, нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, зорилтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
		5.4	Соёл, хүүхэд залуучуудын хөгжлийн бодлого зохицуулалт	5.4.1 Нийслэл, дүүргээс соёл урлаг, хүүхэд, залуучуудын талаар бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх, дээрх чиглэлээр бодлогын зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, хууль, тогтоомжийг дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэх
6	Худалдаа, үйлчилгээ	6.1	Үйлдвэрлэл, үйлчилгээ	6.1.1 Жижиг дунд үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээний бодлого зохицуулалт 6.1.2 Хөдөө аж ахуй, аялал жуулчлалын бодлого, зохицуулалт 6.1.3 Худалдааны бодлого, зохицуулалт 6.1.4 Хүнс, нийт хоолны үйлчилгээний бодлого зохицуулалт

IV. ТӨСВИЙН ЖИЛД НИЙЛҮҮЛЭХ БҮТЭЭГДЭХҮҮН

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АНГИ-1.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭ

Томъёолол

Энэхүү ажил үйлчилгээнд Засаг даргад үзүүлэх захиргааны үйлчилгээ, Захиргаа, хууль эрх зүй, хүний нөөцийн удирдлага, зохицуулалт, үйл ажиллагааны хяналт, шинжилгээ үнэлгээ, гадаад харилцаа, хэвлэл мэдээллийн бодлого зохицуулалт, байгууллагын хөгжлийг хангах ажил үйлчилгээ хамраана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ 1.1 Дүүргийн Засаг даргад үзүүлэх захиргааны үйлчилгээ

Томъёолол

Захирамжлалын баримт бичгийн биелэлт, үүрэг даалгаврыг хангуулах, ЗДТГ-ын жилийн төлөвлөгөөний биелэлтийг хангахад чиглэсэн захиргааны үйлчилгээ үзүүлэх, Засаг даргын өдөр тутмын үйл ажиллагаанд болон Засаг даргаас шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн зохицуулалт хийх, мэдээллээр хангах үйл ажиллагаа /ажил үйлчилгээ/ энэхүү бүтээгдэхүүнд хамаарна.

Ажил, үйлчилгээ 1.1.1 Захирамжлалын баримт бичгийн биелэлт, үүрэг даалгаврыг хангуулж Засаг даргын өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах, мэдээллээр хангах үйл ажиллагаа

Томъёолол

Удирдах дээд байгууллагуудын тогтоол, шийдвэрийн биелэлт, удирдлагаас өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилтэд хяналт тавьж биелэлт, мэдээг тогтоосон хугацаанд гаргаж тайлагнах, мэдээллээр хангах зэрэг ажил үйлчилгээ энд хамаарна.

Хүснэгт 4.1

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Тоо хэмжээ: <ul style="list-style-type: none"> • Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлтийн явцыг дүгнэж мэдээлэхдээ Засгийн газрын холбогдох тогтоолуудын дагуу үнэн зөв хийж, үнэлгээ өгсөн 	Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны

байх <ul style="list-style-type: none"> Нийслэл, ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, шийдвэрийн явцыг дүгнэж мэдээлэхдээ Засгийн газрын 89 дүгээр тогтоол, журам болон загвар маягтуудын дагуу үнэн зөв гаргасан байх Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар тухай бүр биелэгдэж, хэлтсүүдийн ажлын уялдаа холбоо сайжирсан байх 	төлөвлөгөө"-нд тодорхойлов.
Чанар: <ul style="list-style-type: none"> Тамгын газрын дотоод ажил нь хууль, тогтоомж, төрийн албаны стандартын дагуу хийгдэж, хэрэгжилт бүрэн хангагдсан байх 	
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/Өдөр:	
Хугацаа:	

Ажил үйлчилгээ 1.1.2 ЗДТГ-ын жилийн төлөвлөгөөний биелэлтийг хангуулах

Томъёолол

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын календарчилсан төлөвлөгөөг хагас, бүтэн жилээр гарган биелэлтийг хангуулж, ил тод мэдээлэх, удирдлагыг мэдээллээр хангах ажил үйлчилгээ энд хамаарна.

Хүснэгт 4.2

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Тоо хэмжээ: <ul style="list-style-type: none"> Тамгын газрын төлөвлөгөө хугацаандаа хэрэгжиж, шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн биелэгдсэн байх 	Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд тодорхойлов.
Чанар: <ul style="list-style-type: none"> Засаг даргын өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн нөхцөл хангагдсан байна. Тамгын газрын дотоод ажил төрийн албаны стандартын дагуу хийгдэж, хэрэгжилт бүрэн хангагдсан байх 	
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

Хэрэгжүүлэх арга хэмжээ 1.2 Захиргаа, хууль эрх зүй, хүний нөөцийн удирдлага, зохицуулалт

Томъёолол

Дүүргийн нутгийн захиргааны байгууллагыг төрийн захиргааны удирдлага зохицуулалтаар хангах, тэдгээр байгууллагуудад захиргааны стандартыг мөрдүүлэх, төрийн захиргааны шинэтгэлийг хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагаа / ажил үйлчилгээ/ энд хамаарна.

Ажил үйлчилгээ 1.2.1 Хууль, эрх зүйн бодлого зохицуулалт

Томъёолол

Дүүргийн Засаг дарга, Тамгын газрын дарга, иргэдэд хуулийн зөвлөгөө өгч, ЗДТГ-аас боловсруулан гаргаж буй эрх зүйн актуудын хууль зүйн үндэслэлийг хангах, Нийслэлийн Засаг даргаас дүүргийн Засаг даргатай байгуулсан Үр дүнгийн гэрээний биелэлтийг зохион байгуулах, мэдээлэх,

Хүснэгт 4.3

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
<p>Тоо хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> • Дүүргийн Засаг дарга болон төрийн захиргааны байгууллага, иргэдэд өгсөн хуулийн зөвлөгөө, /зөвлөгөө өгсөн иргэдийн тоо/ • Үр дүнгийн гэрээний заалтуудын хэрэгжилт, /хувиар/ • Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх /гэмт хэргийн гаралтын тоо, гэмт хэргийн илрүүлэлтийн тоо/ • Иргэдэд хууль тогтоомж сурталчилсан байдал /тоо, хамрагдсан хувь/ 	<p>Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов.</p>
<p>Чанар:</p> <ul style="list-style-type: none"> • Хуулийн зөвлөгөө, үйлчилгээ хууль тогтоомжид нийцсэн эрх зүйн маргаан гараагүй байх • Хуулийн зөвлөгөө үзүүлэх үйлчилгээг шаардлагын түвшинд хүргэж, иргэдийн хууль, эрх зүйн талаарх мэдлэг дээшилсэн байх • Хууль, тогтоомж, батламж гэрээний хэрэгжилт хангагдаж, үр дүн нь иргэдэд мэдрэгдсэн байх 	
<p>Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.</p>	
Хүн/өдөр:	
Өртөг:	

Ажил үйлчилгээ 1.2.2 Олон нийт, иргэдийн эрэлт хүсэлтийн бодлого зохицуулалт

Томъёолол

Дүүргийн иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдол, эрэлт хүсэлтийг хүлээн авч хуулийн дагуу шуурхай барагдуулах ажлыг зохион байгуулах, эрэлт хүсэлтийн дүн мэдээ, тайланг нэгтгэн өгөгдсөн программын дагуу гаргаж, холбогдох байгууллагад тайлагнах, олон нийттэй харилцах асуудлыг зохицуулах, зохион байгуулах эдгээр асуудлын хүрээн дэх тайлан мэдээ, судалгааг нэгтгэн боловсруулах, тайлагнах, мэдээллээр хангах үйл ажиллагаа энд багтана.

Хүснэгт 4.4

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
------------------	--------------

Тоо хэмжээ: <ul style="list-style-type: none"> Иргэдээс хандсан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тоо хувь Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн тоо хувь 	Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов.
Чанар: <ul style="list-style-type: none"> Өргөдөл, гомдлыг оновчтой шийдвэрлэснээр иргэдийн төрд итгэх итгэл сайжирсан байх Эрэлт хүсэлт хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэгдсэн байх 	
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

Ажил үйлчилгээ 1.2.3 Архив, албан хэрэг хөтлөлт

Томъёолол

Тамгын газрын архив, албан хэргийн хөтлөлт, ёслол хүндэтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулахад чиглэгдсэн үйл ажиллагаа /ажил үйлчилгээ/ багтана.

Хүснэгт 4.5

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Тоо хэмжээ: <ul style="list-style-type: none"> Албан хэрэг хөтлөх, бүрдүүлэх, эмх цэгцтэй хадгалах, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж бүрдүүлсэн баримт бичгийг тоо Баримт бичгийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу төрөлжүүлэн хэрэг бүрдүүлж, хүлээн авсан баримтын тоо Цахим баримт бичгийг хүлээн авах, шуурхай хянан шийдвэрлэх, цахим албан хэрэг хөтлөлтийн талаарх бодлого стандарт журмыг хэрэгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах 	Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов
Чанар: <ul style="list-style-type: none"> Архивын үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх Албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэх 	
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

Ажил үйлчилгээ 1.2.4 Хүний нөөцийн бодлого зохицуулалт

Томъёолол

Хүний нөөцийн болон шагналын асуудлаар төрөөс баримталж буй бодлого, шийдвэрийг дүүргийн Засаг даргын тамгын газрын хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн үндсэн дээр зохион байгуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахиулах үйл ажиллагаа энд хамаарна.

Хүснэгт 4.6

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Тоо хэмжээ: <ul style="list-style-type: none"> Тухайн жилд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо Тухайн жилд ажлын үр дүнгээ үнэлүүлж, урамшуулал хүртсэн албан хаагчийн тоо Тухайн жилд нийгмийн асуудлаа шийдвэрлүүлсэн албан хаагчийн тоо 	Хүрэх түвшинг “Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов.
Чанар: <ul style="list-style-type: none"> Мэдлэг, ур чадвартай чадварлаг аппарат бүрдсэн байх Тамгын газрын үр нөлөө дээшилж, байгууллагын шинэ соёл төлөвшсөн байх Шагналын талаар төрөөс явуулж буй бодлого түүнтэй уялдуулан гаргасан шийдвэр, журамд нийцүүлснээр иргэд сэтгэл ханамжтай болсон байх Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээнд хүнд суртал, авилга үгүй болсноор төрийн албан хаагчийн нэр хүнд өссөн байх 	
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

Хэрэгжүүлэх арга хэмжээ 1.3 Үйл ажиллагааны хяналт, шинжилгээ үнэлгээТомъёолол

Энэ бүтээгдэхүүнд дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн тухайн жилийн зорилтын хэрэгжилт, тогтоол шийдвэр, хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж үр дүнд нь үнэлгээ өгөх үйл ажиллагаа орно.

Ажил үйлчилгээ 1.3.1 Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтын хэрэгжилтийн хяналтТомъёолол

Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт түүний үйл явцад хяналт шинжилгээ хийж засаж сайжруулах, эдийн засаг, нийгмийн зорилтын хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэх зэрэг ажил үйлчилгээ хамаарна.

Хүснэгт 4.7

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Тоо хэмжээ: <ul style="list-style-type: none"> Байгууллагууд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн холбогдох зорилтыг өөрийн жилийн төлөвлөгөөнд тусгасан байх Тухайн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил 	Хүрэх түвшинг “Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов.

үйлчилгээний биелэлтийн хувь	
Чанар:	
<ul style="list-style-type: none"> • Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тавигдсан шалгуур үзүүлэлтийг хангаж, хэрэгжүүлсэн байх • Эдийн засаг, нийгмийн зорилт бүрэн хэрэгжсэн байх 	
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

Ажил үйлчилгээ 1.3.2 Тогтоол шийдвэр, хөтөлбөр, төслийн хэрэгжилтэнд тавих хяналт

Томъёолол

Монгол улсын хууль тогтоомж, дээд байгууллагуудын тогтоол, шийдвэрийн холбогдох заалтуудын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх ажил үйлчилгээ хамаарна.

Хүснэгт 4.8

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Тоо хэмжээ:	Хүрэх түвшинг “Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов.
<ul style="list-style-type: none"> • Тогтоол , шийдвэрийн явцыг дүгнэж мэдээлэхдээ Засгийн газрын 89 дүгээр тогтоол, журам болон загвар маягтуудын дагуу үнэн зөв гаргасан байх 	
Чанар:	
<ul style="list-style-type: none"> • Тогтоол шийдвэр тодорхой, хэмжигдэхүйц байдлаар үнэлэгдэж мэдээлэгдсэн байх 	
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

Хэрэгжүүлэх арга хэмжээ 1.4 Гадаад харилцаа, хэвлэл мэдээллийн бодлого зохицуулалт

Томъёолол

Төр захиргааны байгууллагуудаас явуулж буй бодлого, хэрэгжүүлж буй ажлыг иргэд олон түмэнд сурталчилах ажлыг зохион байгуулах, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, гадаад харилцааны талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, олон нийттэй харилцах болон мэдээллийн технологийн ажлыг зохион байгуулахад чиглэгдсэн үйл ажиллагаа хамаарна.

Ажил үйлчилгээ 1.4.1 Мэдээллийн технологи, сүлжээний ашиглалт, зохицуулалт

Томъёолол

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Эко дүүрэг хөтөлбөрийн хүрээнд хороодыг интернетэд холбох, Тамгын газрын нэгдсэн фортал вэб сайтыг ажиллуулах, интернетийн болон дотоод сүлжээ байнгын хэвийн ажиллагааг хангах, компьютерийн сургалт зохион байгуулах, түүний техник ажиллагааны бэлэн байдлыг хангах, шинэ мэдээллээр хангах, иргэдээс хандаж гаргасан эрэлт хүсэлтийн дагуу лавлагаа, мэдээллийн угтах үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй хүргэх, төрийн үйлчилгээний талаар мэдээллийн сан бий болгож баяжуулахтай холбоотой үйл ажиллагаа хамаарна.

Хүснэгт 4.9

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
<p>Тоо хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> Интернеттэд холбогдсон хороодын тоо Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн тоо Тамгын газрын нэгдсэнфортал вэб сайтыг ашиглагчдын тоо Төрийн мэдээллийн нэгдсэн системтэй холбосон байх Тамгын газраас зохиож буй ажил олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай сурталчилагдсан тоо Албан хаагчдад мэдээллийн технологийн чиглэлээр сургалт явуулсан тоо хамрагдсан хүний тоо Компьютерийн эвдрэл саатлыг оношилж засварласан тоо 	Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов
<p>Чанар:</p> <ul style="list-style-type: none"> Албан хаагчид мэдээллээ саадгүй түргэн шуурхай солилцсон байх Төрийн үйлчилгээний талаархи мэдээлэл иргэдэд ил тод нээлттэй болсон байх Төрийн үйлчилгээ иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй хүрсэн байх 	
<p>Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.</p>	
Хүн/өдөр:	
Өртөг:	

Ажил үйлчилгээ 1.4.2 Гадаад харилцааны бодлого зохицуулалт

Томъёолол

Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт гадаад харилцааны талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үйл ажиллагаа ажил үйлчилгээ энд хамаарна.

Хүснэгт 4.10

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
<p>Тоо хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр дэх гадаад харилцаа хамтын ажиллагааны хэрэгжилтийн 	Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх

байдал	үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд тодорхойлов.
Чанар: <ul style="list-style-type: none"> Гадаад улсуудтай хамтын харилцаа өргөжиж, хоёр талын харилцан ашигтай хамтын ажиллагаа бий болсон байх 	
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

Хэрэгжүүлэх арга хэмжээ 1.5 Байгууллагын хөгжил

Томъёолол

Байгууллагын санхүүгийн болон материаллаг нөөцийг нэмэгдүүлэх, сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа /ажил үйлчилгээ/ хамаарна.

Ажил үйлчилгээ 1.5.1 Тамгын газрын санхүүгийн чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн ажил үйлчилгээ

Томъёолол

Тамгын газрын өөрийн орлогыг нэмэгдүүлэх, өөрийн өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, хуульд заасан бусад эх үүсвэрээс олох орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа /ажил үйлчилгээ/ энд хамаарна.

Хүснэгт 4.11

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Тоо хэмжээ: <ul style="list-style-type: none"> Тамгын газрын өөрийн орлогыг нэмэгдүүлэх Хуульд заасан бусад эх үүсвэрээс олох орлогыг нэмэгдүүлэх Өөрийн өмчлөлийн эд хөрөнгийг ашиглуулах, түрээслүүлэх замаар орлого олох 	Хүрэх түвшинг "Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд тодорхойлов.
Чанар: <ul style="list-style-type: none"> Санхүүгийн чадавхи нэмэгдсэн байх Орлого бүрдүүлэх үйл ажиллагаа хууль тогтоомжийн хүрээнд байх 	
Хугацаа: Дүүргийн засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр	
Өртөг	

Ажил үйлчилгээ 1.5.2 Тамгын газрын материаллаг нөөцийг сайжруулахад чиглэсэн ажил үйлчилгээ

Томъёолол

Тамгын газар, хороодыг шаардлагатай эд зүйлсээр хангах, үйлчилгээний өдөр тутмын ажлыг зохион байгуулж, үйл ажиллагааг нь хянах

Хүснэгт 4.12

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Тоо хэмжээ:	Хүрэх түвшинг

<ul style="list-style-type: none"> • Хороодын барилгад өргөтгөл, засвар хийх • Хороодыг хуваах • Тавилга хэрэгсэл худалдаж авах • Албан хэрэгцээн дэх цаасны хэрэглээг тооцож хяналт тавих • Утасны ярианы төлбөрт хяналт тавих 	“Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов
Чанар: <ul style="list-style-type: none"> • Тавилга хэрэгслийн эдэлгээ удаан байх • Цаасны хэрэглээ буурсан байх • Утасны ярианы хэмнэлт гарсан байх 	
Хугацаа: Дүүргийн засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

БҮТЭЭГДЭХҮҮН-2

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ ЗОХИЦУУЛАЛТ

Томъёолол

Нийслэл, дүүргийн нийгэм эдийн засгийн хөтөлбөр, зорилтын төлөвлөлт, хэрэгжилтээр хангах, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, гэр хорооллын дахин төлөвлөлт зэрэг ажлуудыг хэрэгжүүлэн удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллана.

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Тоо хэмжээ: <ul style="list-style-type: none"> • Нийслэл, дүүргийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, НЭЗ-ийн зорилтод тусгагдсан ажлуудыг зохион байгуулан, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудыг төлөвлөнө. • Төсөл хөтөлбөр боловсруулан гаргасан ажлын тоо 	Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов
Чанар: <ul style="list-style-type: none"> • Иргэдийн амьдрах орчин сайжирсан байх 	
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	

Томъёолол

Улс нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын талаар баримтлах бодлогыг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан тухайн салбарын холбогдох хууль, тогтоол, захирамжуудыг сурталчилах, биелэлтэд нь хяналт тавих бөгөөд эдгээрт нийт 6776 /7х968/ ажиллах хүн өдөр зарцуулагдана.

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Тоо хэмжээ: <ul style="list-style-type: none"> • Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөн хүргүүлсэн ажлын саналын тоо хэмжээ • Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын гүйцэтгэлийн ажлын тоо хэмжээ 	Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов
Чанар: <ul style="list-style-type: none"> • Дүүрэгт орох хөрөнгө оруулалтын ажлууд нэмэгдсэн байх 	

<ul style="list-style-type: none"> Иргэдийн амьдарлын чанар нэмэгдсэн байх 	
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

Томъёолол:

Нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, НЭЗЗ –ийн бодлогыг боловсруулан хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж улирал жилээр тайлан мэдээ гаргах

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Тоо хэмжээ: <ul style="list-style-type: none"> Нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг улирал, хагас жил, жилийн эцэст гаргахдаа хувийг ахиулсан байх Тухайн жилийн нийслэл, дүүргийн НЭЗЗ-ын биелэлтийн хувь жилийн эцсээр 90-ээс дээш хувьтай байх Засгийн газрын 89 дүгээр тогтоолыг үндэслэн үнэлгээ өгсөн байх 	Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов
Чанар: <ul style="list-style-type: none"> Засгийн газрын 89 дүгээр тогтоолын дагуу хяналт, шалгалт хийгдсэн байх ёстой бөгөөд биелэлтийг үнэн зөв, хангалттай гаргуулсан байх Нийгэм эдийн засгийн зорилт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан заалт бүрийг хянаж, үнэлгээ өгөн, хангалтгүй заалтууд дээр тулгуурлан хэлтэс, албадтай хариуцлага тооцдог байх 	
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

Томъёолол

Орон нутагт шаардлагатай хөрөнгө оруулалтын ажлын саналыг нэгтгэн, Улс, Нийслэлийн төсөвт тусгуулах, хэрэгжилтэнд хяналт тавих- Холбогдох байгууллагуудаас ирүүлсэн хөрөнгө оруулалтын саналыг нэгтгэн зураг төсөв шаардлагатай ажлуудад зураг хийлгэх, бэлэн зурагтай болсон ажлуудыг Улс, Нийслэлийн төсөвт тусгуулах албан бичгийг дээд шатны байгууллагуудад хүргүүлэх ажлууд багтана.

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Тоо хэмжээ: <ul style="list-style-type: none"> Боловсруулж хүргүүлсэн хөрөнгө оруулалтын ажлын тоо Төсөл хөтөлбөр боловсруулахад нь арга зүйн зөвлөгөө өгсөн тоо 	Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны

Чанар: <ul style="list-style-type: none"> Барилгын норм дүрэм стандартад нийцсэн ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг боловсруулсан байх Иргэд амьдрах орчин сайжирсан байх 	төлөвлөгөө"-нд тодорхойлов
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	

Томьёолол

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг боловсруулан зураг төслийн ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавих

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Тоо хэмжээ: <ul style="list-style-type: none"> Боловсруулсан хөрөнгө оруулалтын ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын тоо Төсөл хөтөлбөр боловсруулахад нь арга зүйн зөвлөгөө өгсөн тоо 	Хүрэх түвшинг "Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд тодорхойлов
Чанар: <ul style="list-style-type: none"> Барилгын норм дүрэм стандартад нийцсэн ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг боловсруулсан байх Иргэд амьдрах орчин сайжирсан байх 	
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

Томьёолол

Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, Нийслэл, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас батлагдсан дэд хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлж, удирдан, зохион байгуулах

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Тоо хэмжээ: <ul style="list-style-type: none"> ЗГ болон Нийслэлийн ИТХ-аар батлагдсан хөтөлбөрт хяналт шинжилгээ үнэлгээ хийж хэрэгжүүлэх хяналт тавих 	Хүрэх түвшинг "Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд тодорхойлов
Чанар <ul style="list-style-type: none"> нийслэл дүүргээс явуулах бодлого, шийдвэр бүтээн байгуулалтын ажлын чанар сайжирч, иргэдийн оролцоо нэмэгдсэн байна Иргэдийн амьдрах орчин сайжирсан байх 	
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

Томъёолол

ЗГ болон Нийслэлийн ИТХ-аар батлагдсан хөтөлбөрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан мэдээ гаргах. Засгийн газрын 89-р тогтоолын хавсралтад заасны дагуу хэрэгжиж буй хөтөлбөрийн биелэлтийг жил бүрийн 12-р сарын 20-ны өдрийн дотор нэгтгэн гаргаж холбогдох газруудад хүргүүлнэ.

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Тоо хэмжээ: <ul style="list-style-type: none">Төсөл хөтөлбөрт иргэдийн саналыг тусгах чиглэлээрТөсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн мэдээ тайлан гаргахСургалт, хурал, зөвлөгөөнд хамруулсан тоо, үр дүн	Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов
Чанар: <ul style="list-style-type: none">Хэлтсийн ажилтнуудын мэргэшил, мэдлэг дээшлэн хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явагдаж хэвшсэн холбогдох хууль тогтоомж стандартад нийцсэн байхНийслэл дүүргээс явуулах бодлого, шийдвэр бүтээн байгуулалтын ажлын чанар сайжирж, иргэдийн оролцоо нэмэгдсэн байна	
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

Томъёолол

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажил үйлчилгээг удирдлага зохион байгуулалтаар ханган, хэрэгжилтэд хяналт тавих- Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналын хуудсыг иргэдээр бөглүүлэн хэрэгжүүлэх хөрөнгө оруулал эрэмбэлэх бөгөөд тус эрэмбэлэн ирүүлсэн саналд анализ дүгнэлт хийн хэрэгжих боломжтой эсэхийг тодорхойлон Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралаар хэлэлцүүлэн батлуулах ажил хийгдэнэ.

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Тоо хэмжээ: <ul style="list-style-type: none">Орон нутгийн хөгжлийн асуудалд иргэдийн оролцоог хангасан тоо хэмжээОрон нутагт хийгдсэн ажлын гүйцэтгэлийн тоо хэмжээ хувьХөрөнгө оруулалтын ажлын даалгавар, зураг төслийн ажлын тоо хэмжээ	Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов.
Чанар: <ul style="list-style-type: none">Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулан чанарыг сайжруулсан байхТөрийн үйлчилгээний талаар иргэдийн сэтгэл ханамж	

дээшилсэн байх	
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

Томьёолол

Гэр хорооллын бүсийг нийгэм, эдийн засаг, байгал орчны зохистой харьцааг хангах суурьшлын бүс болгон хөгжүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулах

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Тоо хэмжээ: <ul style="list-style-type: none"> Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн орон сууцыг дахин төлөвлөн барилгажуулах журмын хуучин орон сууцны барилгуудыг дахин төлөвлөн барилгажуулах Гэр хорооллын дахин төлөвлөлт, газар шинэчлэн зохион байгуулалтын үйл ажиллагааны журамтай холбоотой үйл ажиллагаа Дахин төлөвлөлттэй холбоотой хийгдсэн ажлын тоо хэмжээ 	Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов
Чанар: <ul style="list-style-type: none"> Дахин төлөвлөлтөнд хамрагдсан иргэдийн тоо Иргэдийн амьдралын чанар нэмэгдсэн байх 	
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

Томьёолол

Гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд зохион байгуулан мэдээ тайланг гаргах

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Тоо хэмжээ: <ul style="list-style-type: none"> Гэр хорооллын дахин төлөвлөлтийн талаар хийсэн уулзалт Иргэдийн бүлгийн тоо 	Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов
Чанар: <ul style="list-style-type: none"> Дахин төлөвлөлтөнд хамрагдсан иргэдийн тоо Иргэдийн амьдарлын чанар нэмэгдсэн байх 	
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

Томьёолол

Ашиглалтын шаардлага хангахгүй Нийтийн орон сууцны барилгын дахин төлөвлөлттэй холбоотой үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд зохион байгуулан тайлан, мэдээ гаргах

Тоо хэмжээ: <ul style="list-style-type: none">Ашиглалтын шаардлага хангахгүй Нийтийн орон сууцны барилгын дахин төлөвлөлттэй холбоотой талаар хийсэн уулзалтЗохион байгуулсан ажлын тоо	Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов
Чанар: <ul style="list-style-type: none">Дахин төлөвлөлтөнд хамрагдсан иргэдийн тооИргэдийн амьдралын чанар нэмэгдсэн байх	
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АНГИ-3.

ДҮҮРГИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

Томьёолол

Энэхүү бүтээгдэхүүний ангид дүүргийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн стратегийг төлөвлөх, бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулахад чиглэсэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ хамаарна. Бүтээгдэхүүний энэ ангид хамаарах 2 нэр төрлийн бүтээгдэхүүнийг нийлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа /ажил үйлчилгээ/-г зохион байгуулах, хэрэгжүүлэх бөгөөд эдгээрт нийт хүн-өдөр зарцуулагдана.

1.1 Санхүү, төсвийн бодлого, зохицуулалт

Томьёолол

Төрөөс батлагдсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, дүүргийн нийгэм эдийн засгийн зорилт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд төсвийн бодлогыг чиглүүлэн ажиллах, дүүргийн санхүү, эдийн засгийн бодлогыг тодорхойлж, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулахад хяналт тавин, орон нутгийн эдийн засгийн тэнцвэрт байдлыг ханган ажиллах, Засаг даргыг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь мэргэжлийн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа, ажил үйлчилгээ энэхүү бүтээгдэхүүнд хамаарах бөгөөд нийт 5821 хүн өдөр зарцуулагдана.

Үйл ажиллагаа /ажил үйлчилгээ/ 1.1.1 Төсөө, санхүүгийн төлөв байдал, хандлага, чиглэлийн боловсруулалт

Томьёолол

Энд дүүргийн эдийн засгийн хөгжил, төсвийн дунд хугацааны стратеги, дараагийн жилийн төсвийн бодлого, үндсэн чиглэлийг боловсруулах, эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг хангах бодлого боловсруулах, дүн шинжилгээ хийх, хэрэгжилтийг зохион байгуулах, бодлогын зөвлөгөө өгөх, шийдвэрийн төсөл боловсруулах, судалгаа хийх ажил үйлчилгээ хамаарна.

Хүснэгт 4.20

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Тоо хэмжээ: <ul style="list-style-type: none"> Орон нутгийн төсвийн жилийн болон дунд хугацааны төслийг үндэслэлтэй боловсруулах, хянах, нэгтгэн тооцоолж Нийслэлийн СТСХ-т хүргүүлж нэгтгүүлэх, дүүргийн ИТХ-д өргөн барьж батлуулах, тухайн оны сар улиралын хуваарийг хийх, төсвийн зориулалт, зарцуулалтанд хяналт тавих, төсвийн байгууллагаас нийлүүлэх бүтээгдэхүүнийг эцсийн үр дүнгээр нь санхүүжүүлэн төсвийн бодит хэмнэлт үр ашгийг дээшлүүлэн удирдлагыг цаг үеийн үнэн зөв мэдээлээр хангах 	Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов.
Чанар: <ul style="list-style-type: none"> Төсөв холбогдох хууль тогтоомж, стандартад нийцсэн байх, хуулийн хугацаанд батлагдаж санхүүжилт олгогдсон байх Төсөв бодитой төсөвлөгдсөн байх, үйл ажиллагаа хэвийн явагдаж өр, авлагагүй ажилласан байх 	
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

Үйл ажиллагаа /ажил үйлчилгээ/ 1.1.2 Төсөв, санхүүгийн бодлого, зохицуулалт, тайлагнал

Томьёолол

Төсөвт байгууллагуудын тайлан тэнцлийг хүлээн авч баталгаажуулах, дүүргийн төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлан тэнцлийг гаргах, Улсын секторын НББОУС-ыг нэвтрүүлж, бүртгэл хөтлөлтийг төсөвт байгууллагуудад бүрэн хангуулах, нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлийг гүнзгийрүүлэх, Төсвийн тухай хуулийг хэрэгжилтийг ханган нягтлан бодогч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлж, удирдлагыг мэдээллээр хангана.

Хүснэгт 4.21

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Тоо хэмжээ: <ul style="list-style-type: none"> Төрийн сангийн нэгж төсөвт байгууллагуудад Засгийн газрын шинэчилсэн бүртгэл болон улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг хэрэгжүүлэх ажлыг хангуулах. Төсөвт байгууллагуудын тайлан тэнцлийг хүлээн авч баталгаажуулан нэгтгэл хийж, орон нутгийн болон төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлан тэнцлийг гарган аудитын байгууллагаар баталгаажуулан, төсвийн зардлын гүйцэтгэлд судалгаа шинжилгээ хийх. Сургалт семинарыг тогтмол зохион байгуулж ажилласан байх, мэргэшсэн нягтлан бодогчдын тоо нэмэгдсэн байх 	Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов.
Чанар: <ul style="list-style-type: none"> Төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд нь нэгтгэн тушаасан байх төсвийн орлого зарлагын сарын мэдээг 	

<p>тогтмол гаргаж тушаасан байх</p> <ul style="list-style-type: none"> Санхүү төсвийн сахилга батыг ханган биелүүлж, зөрчилгүй ажилласан байх. 	
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

Үйл ажиллагаа /ажил үйлчилгээ/ 1.1.3 Төрийн сангийн үйлчилгээ

Томьёолол

Төрийн сангийн төлбөр тооцооны системээр дамжуулан төсөвт байгууллагуудын төсвийн хэрэгжилт, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг хангахтай холбоотой төсвийн ерөнхий болон бүртгэлийн дансны бэлэн болон бэлэн бус төлбөр тооцоог гүйцэтгэх, банк санхүүгийн бүртгэл тооцооны ажлыг хуулийн хүрээнд зохион байгуулж, хяналт тавьж удирдлагыг мэдээллээр хангах үйл ажиллагаа ажил үйлчилгээ хамаарна.

Хүснэгт 4.22

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
<p>Тоо хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> Төрийн сан банкаар үйлчлүүлэгч төсөвт байгууллагуудын тоо, хийгдэж байгаа банк хоорондын болон дотоод гүйлгээний тоо ЗГСУМС-дэх бэлтгэн нийлүүлэгчийн тоо 	<p>Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов.</p>
<p>Чанар:</p> <ul style="list-style-type: none"> Санхүү, банкны үйл ажиллагаа хэвийн явагдаж төсвийн сахилга батыг ханган биелүүлж, зөрчилгүй ажилласан байх Дүүргийн харьяа төсөвт байгууллагуудын төрийн санд болон арилжааны банкинд нээгдсэн дансны хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байх Төсөвт байгууллагын төлбөр тооцоог программд эцэслэн гүйцэтгэж хэвшсэн байх, программыг ажилдаа бүрэн нэтрүүлсэн байх 	
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

Үйл ажиллагаа ажил үйлчилгээ 1.1.4 Төсвийн орлогын бүрдүүлэлт

Томьёолол

Төсвийн орлогын дунд хугацааны төсөөлөл, жил бүрийн төсвийн орлогын төсөл боловсруулах, татварын бааз суурийг өргөтгөх, төсвийн орлогын бүрдүүлэлтэд хяналт тавих, судалгаа дүгнэлт хийх, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах үйл ажиллагаа ажил үйлчилгээ хамаарна.

Хүснэгт 4.23

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
<p>Тоо хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> Төсвийн орлогын төлөвлөгөө жигд ханган биелэгдсэн байх 	<p>Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн</p>
Чанар:	

<ul style="list-style-type: none"> • Санхүү, банкны үйл ажиллагаа хэвийн явагдаж өр авлагагүй ажилласан байх • Татварын бааз суурийг нэмэгдүүлж, тухайн зөрчлийг арилгасан байх 	нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд тодорхойлов.
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

Үйл ажиллагаа ажил үйлчилгээ 1.1.5 Нягтлан бодох бүртгэлийн стандартыг хангуулах

Томьёолол

Аж ахуй нэгж байгууллагуудын санхүүгийн тайлан тэнцлийг хүлээн авч баталгаажуулах, нэгтгэх, судалгаа шинжилгээ хийх, НББОУС-ыг нэвтрүүлж бүртгэл хөтлөлтийг дүүргийн хэмжээнд бүрэн хангуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодогч нарын мэргэшил, мэдлэгийг дээшлүүлэх, сургалт семинар зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа /ажил үйлчилгээ/ хамаарна.

Хүснэгт 4.24

Шалгуур үзүүлэлт:	Хүрэх түвшин
Тоо хэмжээ: <ul style="list-style-type: none"> • НББОУС нэвтрүүлсэн байгууллагын тоо 	Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов.
Чанар: <ul style="list-style-type: none"> • Тайлан тэнцлийн нэгтгэлийг хуулийн хугацаанд зохих дээд байгууллагад хүргүүлсэн байх • Ажлын тайлан болон хугацаат мэдээг хуулийн хугацаанд нь хүргүүлсэн байх 	
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн-өдөр:	
Өртөг:	

Үйл ажиллагаа /ажил үйлчилгээ/ 1.1.6 Хөрөнгө оруулалт, орон нутгийн өмчийн бүртгэл

Томьёолол

Орон нутгийн өмч хөрөнгө болон нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн дүнг нэгдсэн тооллогоор гаргаж бүртгэлийг сайжруулах, ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх, дүүргийн нийгэм, эдийн засаг, хөгжлийн чиглэл, хөтөлбөр, төсөл боловсруулах, эдийн засгийн үзүүлэлтээр нэгтгэл хийж, мэдээ мэдээллээр удирдлагыг хангах үйл ажиллагаа ажил үйлчилгээ хамаарна.

Хүснэгт 4.25

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Тоо хэмжээ: <ul style="list-style-type: none"> • Хөрөнгө оруулалт • Төсөл, хөтөлбөр 	Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл
Чанар:	

<ul style="list-style-type: none"> • Бүртгэл сайжирч, мэдээллийн сан бүрдэж ашиглалт сайжирсан байх • Тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын ажлууд нь хуулийн дагуу хугацаандаа, чанартай гүйцэтгэгдсэн байх 	ажиллагааны төлөвлөгөө"-нд тодорхойлов.
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

БҮТЭЭГДЭХҮҮН АНГИ-4

ДЭД БҮТЦИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

Томьёолол

Дүүргийн дэд бүтэц, орон сууц, нийтийн аж ахуй, барилга зам, холбооны талаар баримтлах бодлогыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан тухайн салбарын холбогдох хууль, тогтоол, захирамжуудыг сурталчилах, биелэлтэд нь хяналт тавихад чиглэсэн үйл ажиллагаа ажил үйлчилгээ зохион байгуулах хэрэгжүүлэх бөгөөд эдгээрт нийт 6776 /7x968/ ажиллах хүн өдөр зарцуулагдана.

Хүснэгт 4.26

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Тоо хэмжээ: <ul style="list-style-type: none"> • Нийтийн эзэмшлийн зам, талбайн ашиглалт хамгаалалтыг сайжруулсан тоо хувь • Инженерийн байгууламжийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах 	Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов.
Чанар: <ul style="list-style-type: none"> • Дэд бүтэц сайжирч, иргэдийн сэтгэл ханамж дээшилсэн байх • Нийтийн эзэмшлийн зам, талбайн ашиглалт хамгаалалт сайжирсан байх • Алслагдсан хороод болон дүүргийн ард иргэдэд түргэн шуурхай, доголдолгүй үйлчлэх • Төрийн үйлчилгээний талаар иргэдийн сэтгэл ханамж дээшилсэн байх 	
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

Үйл ажиллагаа ажил үйлчилгээ 3.1.2 Дүүргийн тохижилт, СӨХ-ын бодлого зохицуулалт

Томьёолол

Дүүргийн тохижилт, гэрэлтүүлэг, ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт, хог хаягдал, СӨХ-дын талаар баримтлах бодлого төлөвлөгөөг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан тухайн салбарын холбогдох хууль, тогтоол, захирамжуудыг сурталчлах, биелэлтэд нь хяналт тавих үйл ажиллагааны ажил үйлчилгээ хамаарна.

Хүснэгт 4.27

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
<p>Тоо хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> • Тохижилт, ногоон байгууламж, хог хаягдлын түвшинг сайжруулсан байх • Мод, бут сөөг тарих, суулгах ажилд аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг оролцуулсан тоо хамрагдсан хувь • Аж ахуйн нэгж байгууллага болон айл өрхүүд, нийтийн эзэмшлийн болон орон сууцны дунд хоггүй орчин бий болгох • Аж ахуйн нэгж байгууллагууд, СӨХ-ийн үйл ажиллагаа, гаднах орчны тохижилтын ажлыг зохион байгуулж олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан тоо • Хууль тогтоомж, Нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудын хэрэгжилтийн байдал 	<p>Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов</p>
<p>Чанар:</p> <ul style="list-style-type: none"> • Аж ахуйн нэгж байгууллага бүрийн гадна тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн ажил хийгдэж хотын өнгө төрх сайжирсан байх • Хууль тогтоомж, Нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байх. 	
<p>Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.</p>	
Хүн/өдөр:	
Өртөг:	

3.1.1 .Агаарын бохирдлыг бууруулах талаар

Томьёолол

Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд агаарын бохирдлыг бууруулах талаар баримтлах бодлогыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан тухайн салбарын холбогдох хууль, тогтоол, захирамжуудыг сурталчилах, биелэлтэд нь хяналт тавихад чиглэсэн үйл ажиллагаа ажил үйлчилгээ зохион байгуулах хэрэгжүүлэх бөгөөд эдгээрт нийт 6776 /7х968/ ажиллах хүн өдөр зарцуулагдана.

Хүснэгт 4.28

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
<p>Тоо хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> • Айл өрхүүдэд утаагүй зуухыг хэрэглэж хэвшүүлэх талаар сургалт сурталчилгаа зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах • Хууль тогтоомж, Нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудын хэрэгжилтийн байдал 	<p>Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов</p>

Чанар:	
<ul style="list-style-type: none"> Хууль тогтоомж, Нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байх. Утаагүй зуух, утаагүй түлш хэрэглэдэг айл өрхүүдийн тоо нэмэгдэж, утааны хэмжээ тодорхой түвшинд бууруулсан байна. 	
Хугацаа:	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.
Хүн/өдөр:	
Өртөг:	

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АНГИ 5.

НИЙГМИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ

Томьёолол

Дүүргийн хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын цогц бодлогыг хэрэгжүүлж, боловсрол, төрийн бус байгууллага, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, хүүхэд залуучуудын чиглэлээр төрөөс гарсан хууль тогтоомж, бодлого, шийдвэр, дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай, чанартай, тэгш хүртээмжтэй хүргэхэд оршино.

5.1 Үйл ажиллагаа /ажил үйлчилгээ/ Боловсрол, төрийн бус байгууллагын бодлого, зохицуулалт

Томьёолол

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулж, төр, ТББ-ын уялдаа холбоог хангаж ажиллах

Ажил үйлчилгээ 5.1.1 Дүүргийн Засаг даргаас боловсрол, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах талаарх бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх, дээрх чиглэлээр бодлогын зөвлөгөө, мэдээллээр хангах, төрөөс боловсрол, төрийн бус байгууллагын талаар баримтлах бодлого хууль тогтоомжийг дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, боловсролын чиглэлээр төрийн болон бус байгууллагын ажлын уялдаа холбоог зохицуулах үйл ажиллагаа ажил үйлчилгээ хамаарна.

Хүснэгт 4.29

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Тоо хэмжээ:	Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов.
<ul style="list-style-type: none"> Боловсрол, төрийн бус байгууллагуудтай хамтран ажилласан тоо 	
Чанар:	
<ul style="list-style-type: none"> Боловсролын талаар баримталж буй бодлого чиглэл дүүргийн хэмжээнд бүрэн хэрэгжсэн байх Боловсролын чиглэлээр ажиллагсдын мэргэжлийн заах арга, ур чадварт ахиц, дэвшил гарсан байх Сурагчдын сурлагын амжилт чанар дээшилсэн байх Төрийн бус байгуулагатай хамтын ажиллагаа, уялдаа холбо сайжирсан байх 	
Хугацаа:	
Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны	

төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

Үйл ажиллагаа 5.2. Эрүүл мэнд, биеийн тамирын бодлого зохицуулалт

Томьёолол

Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах бодлого зорилтыг хэрэгжүүлэх, биеийн тамирын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх

Ажил үйлчилгээ 5.2.1

Эрүүл мэнд биеийн тамирын чиглэлээр Нийслэл, дүүргийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, Засаг даргад бодлогын зөвлөгөө өгөх, иргэдийн өөрсдийн оролцоог нэмэгдүүлэх замаар эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх

Хүснэгт 4.30

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
Тоо хэмжээ: <ul style="list-style-type: none"> Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдал Хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтийн хувь Эрүүл мэндийн сургалт сурталчилгааг явуулсан тоо, хамрагдалтын хувь Олон нийтийн дунд биеийн тамир спортын арга хэмжээг зохион байгуулсан тоо Иргэдэд спортын сургалт зохион байгуулсан тоо, хамрагдсан хувь 	Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов.
Чанар: <ul style="list-style-type: none"> Эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ сайжрах Хүн амын дундах эрүүл мэндийн дадал хандлага өөрчлөгдсөн байх Дүүргээс зохиогдож буй спортын тэмцээн уралдаанд иргэд, аж ахуй нэгж байгууллагууд өргөнөөр хамрагдсан байх 	
Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

Үйл ажиллагаа ажил 5.3 Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын бодлого зохицуулалт

Томьёолол

Дүүргийн Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд төрөөс хөдөлмөр, нийгмийн хамгааллын талаарх хууль тогтоомж, ядуурал, ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн талаар баримталж буй бодлого, зорилтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

Ажил үйлчилгээ 5.3.1

Хүснэгт 4.31

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
------------------	--------------

<p>Тоо хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлсэн хувь • Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн байгууллага, ажилтнуудын үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирсан байдал • Иргэдэд үзүүлэх халамжийн үйлчилгээний тоо • Ажилгүйдлийг бууруулсан тоо /хувь/ • Хөдөлмөр, халамж үйлчилгээний сургалт сурталчилгаа явуулсан тоо, хамрагдалтын хувь 	<p>Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов.</p>
<p>Чанар:</p> <ul style="list-style-type: none"> • Иргэдэд үзүүлэх хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чанарт өөрчлөлт гарсан байх 	
<p>Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.</p>	
<p>Хүн/өдөр:</p>	
<p>Өртөг:</p>	

Үйл ажиллагаа 5.4 Соёл, хүүхэд залуучуудын хөгжлийн бодлого зохицуулалт

Томьёолол

Соёл урлаг, хүүхэд залуучуудыг чиглэлээр төрөөс баримталж буй бодлого, зорилтын хүрээнд дүүргийн хэмжээнд бодлого боловсруулан хэрэгжүүлэх

Ажил үйлчилгээ 5.4.1 Дүүргийн Засаг даргаас соёл урлаг, хүүхэд, залуучуудын талаар бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх, дээрх чиглэлээр бодлогын зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах төрөөс соёл, урлаг, хүүхэд, залуучуудын талаар баримтлах бодлоготой уялдуулан төсөл хөтөлбөр боловсруулах, хууль, тогтоомжийг дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэх

Хүснэгт 4.32

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
<p>Тоо хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> • Дүүргийн хэмжээнд соёл урлаг, хүүхэд залуучуудын талаар баримтлах бодлогыг төрөөс баримталж буй бодлоготой уялдуулсан төсөл, хөтөлбөрийн тоо • Хариуцсан салбарын ажилтнуудын үйл ажиллагааг шалгасан тоо 	<p>Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов.</p>
<p>Чанар:</p> <ul style="list-style-type: none"> • Соёл урлаг, хүүхэд, залуучуудын талаарх хөгжлийн бодлого, чиглэлийг хэрэгжүүлэхэд оруулсан хувь нэмэр дээшилсэн байх • Соёл урлаг, хүүхэд залуучуудын чиглэлээр ажиллагсдын мэргэжлийн заах арга, ур чадварт ахиц, дэвшил гарсан байх • Хүүхэд, залуучуудад чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлсэн байх • Холбогдох хууль, тогтоомжууд хэрэгжиж хяналт сайжран, биелэлтийг тооцож, дүгнэлт хийж ажилласан байх. 	

Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.	
Хүн/өдөр:	
Өртөг:	

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АНГИ-6

ДҮҮРГИЙН ХҮНС, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ

Томьёолол

Дүүргийн хүн амын хүнсний аюулгүй байдал, хангамж, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, салбарын бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх замаар төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ 6.1 Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ

Ажил үйлчилгээ 6.1.1 Үйлдвэрлэл инноваци, авто үйлчилгээний бодлого, зохицуулалт, арга зүйн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

Томьёолол

Төрөөс баримталж буй жижиг, дунд үйлдвэрлэл, авто үйлчилгээг дэмжих, бодлогыг хүрээнд дүүргийн үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг тодорхойлох, мэдээ мэдээллээр хангах, иргэдэд хүнсний аюулгүй байдлыг бүрэн хангасан бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл, үйлчилгээ үзүүлэхэд хяналт тавих, мэргэжлийн зөвлөгөө өгөх, стандартын мөрдөлтөд хяналт тавих үйл ажиллагаа ажил үйлчилгээ хамаарна.

Хүснэгт 4.33

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
<p>Тоо хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> Дүүргийн үйлдвэрлэл, бичил бизнес эрхлэгчид, авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдийн суурь судалгаа бүрэн гарсан байх. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, авто үйлчилгээ эрхлэгчдэд сургалт сурталчилгаа явуулсан тоо хамрагдалтын хувь Жижиг дунд үйлдвэрлэл, бичил бизнес эрхлэгч, авто үйлчилгээ эрхлэгчдийг сургалт, хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн худалдаанд хамруулсан тоо, үр дүн Жижиг дунд үйлдвэр, авто үйлчилгээ эрхлэгчдийг үйл ажиллагаандаа инноваци нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж байгуулагатай танилцуулах, туршлага судлах аялал зохион байгуулах, түншлэл бий болгосон байдал 	<p>Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов</p>
<p>Чанар:</p> <ul style="list-style-type: none"> Шийдвэр нь иргэдийн хүсэл сонирхолд нийцэж, нийгмийн таатай орчин бүрдүүлэхэд нөлөөлсөн байх Хэлтсийн ажилтнуудын мэргэшил мэдлэг дээшлэн хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явагдаж хэвшсэн холбогдох хууль тогтоомж стандартад нийцсэн байх Жижиг дунд үйлдвэр, авто үйлчилгээ эрхлэгчид хууль тогтоомж, нийслэл дүүргээс явуулах бодлого шийдвэрийн талаар 	

<p>мэдээлэлтэй болж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний чанар сайжирсан байх</p> <ul style="list-style-type: none"> Авто үйлчилгээний чанарт ахиц гарч, хүн амын сэтгэл ханамж дээшилсэн байх 	
<p>Хугацаа: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд жилийн турш гүйцэтгэнэ.</p>	
<p>Хүн/өдөр:</p>	
<p>Өртөг:</p>	

Ажил үйлчилгээ 6.1.2 Хүнс, хөдөө аж ахуйн бодлого зохицуулалт

Дүүргийн хэмжээнд хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хангамж нөөцийг бүрдүүлэх, холбогдох хууль тогтоомжуудыг сурталчлах, биелэлтэд нь хяналт тавьж ажиллах үйл ажиллагаа ажил үйлчилгээ хамаарна.

Хүснэгт 4.34

Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
<p>Тоо хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо нэмэгдсэн, амьжиргааны түвшин дээшилсэн, дүүргийн хэмжээнд хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд хэмжээ өссөн байдал, түүний хувь Мал аж ахуй, гахай шувууны фермерийн аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мах сүүний чиглэлийн шилмэл үүлдрийн малын тоо толгойг нэмэгдүүлсэн байдал Мал аж ахуй, газар тариалан эрхлэгчдийг сургалтанд хамруулах, туршлага судлах аялалд хамруулах, түншлэл бий болгосон байдал Гадаад орнуудад зохион байгуулагдаж буй сургалт, хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн худалдаан хамруулсан тоо, үр дүн Дүүргийн хэмжээнд хадлан тэжээл, ургац хураалтын тоо дээшилсэн байдал, түүний хувь Гадны хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын тоо 	<p>Хүрэх түвшинг “Бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлов</p>
